

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-8

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/ 3-8

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
11 дүгээр сарын 20-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 13 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Г.Ганбаатар, П.Мөнхтулга;
Чөлөөтэй: П.Сайнзориг, З.Мэндсайхан, Д.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Ч.Номин;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Д.Жаргалсайхан, Д.Пүрэвдаваа.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Золбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал, Г.Нарантуяа нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Б.Мөнхсоёл нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 19 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ҮҮРИЙНТУЯА

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
12 цаг 13 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Үүрийнтуяа: Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 11 сарын 20-ны өдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаан өнөөдөр эхэлж байна. Байнгын хорооны эрхэм гишүүддээ болон ажлын хэсгийн гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төсвийн байнгын хорооны 2025 оны 11 сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирсэн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Далайн Батбаяр, Жадамбын Батсуурь, Пүрэвжавын Ганзориг, Батжаргалын Заяабал, Банзрагчийн Түвшин, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Ринчинболдын Батболд, Жадамбаагийн Баясгалан, Хассуурийн Ганхуяг, Баатаржавын Мөнхсоёл, Даваагийн Цогтбаатар, Жигжидийн Батжаргал, Хөххүүгийн Болормаа, Цэрэнпилийн Даваасүрэн, Ганзоригийн Тэмүүлэн, Баттогтохын Чойжилсүрэн. Ирц 55,2 хувьтай байгаа учраас өнөөдөр Байнгын хорооны хуралдааныг эхлүүлье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 10 сарын 30-ны өдөр өргөн барьсан. Энэ Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг өнөөдөр хийнэ. Ингээд санал, дүгнэлтээ бид Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх байгаа. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу? Хэлэлцэх асуудалтай холбоотой санал алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсыг 2026-аас 30 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Энэхүү тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Занданбазарын Цэдэнжав, Шинжлэх ухааны академийн академич Түвдийн Дорж, Дорж академич, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ширэнчулууны Батбаяр орж ирээгүй байна уу? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Лхагвасүрэнгийн Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Бямбасүрэнгийн Даваацэрэн, Цахим

хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чулуунцэцэгийн Золбаяр, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дагвадоржийн Очирбат, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Булгаагийн Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Лхагвабаярын Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Батболдын Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ядамдоржийн Жавхлан, Батлан хамгаалах яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Мажигжавын Мөнхбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны газрын дарга Баасансүрэнгийн Алимаа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэдэнгомбын Болорчулуун, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баярмаагийн Туяа.

Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү? Орохгүй байх юм. Тийм, асуулт асуух, үг 2 цуг явж байгаа биз дээ. Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Баярлалаа, та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ лоозонгийн шинж чанартай төлөвлөгөө бол баталдаг болчихлоо. Одоо тэгэхдээ энэ дээрээсээ асууя даа. Эдийн засгийн хөгжлийн яам боловсруулсан юм шиг энийг. Даваасүрэн гишүүн санаачлаад нэг бяслагийн үйлдвэр хийсэн, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгох дээр нэлээн шүүмжлэл дагуулсан. Тэгээд яг тэрэн шиг тодорхой болгочихсон байгаа судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, тоног төхөөрөмжийн ч гэдэг юм уу судалгаанууд яг бэлэн байна уу? Тэгэхгүй одоо энэчээ биччихсэнээр бол аягүй яг жинхэнээсээ лоозон л биччихсэн байгаад байна л даа. Боловсруулах үйлдвэр барина, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ гээд. Яг тодорхой болгочихсон юмнууд байвал хийж эхлэхгүй бол бид зүгээр цаас батлаад ямар ч нэмэргүй л болчихоод байна 1 дүгээрт.

2 дугаарт энэ Монголбанкнаас энэчээ төлөвлөгөө дээр тусгасан юмнууд байна. Тэгээд Монголбанкнаас асуух гэхээр хүн байхгүй байх шиг байх юм ажлын хэсэгт, асуучихаар чинь одоо хариулах хүн байхгүй байна гэж ойлгох уу? Энд баахан инфляц бууруулна л гэдэг юм биччихсэн байна. Тэгэхдээ энэ Монголбанкин дээр чинь инфляц нэг ажил мөн, хоёр дахь ажил бүр эхний хамгийн том зорилгын ажил Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгийн үнэ цэнийг хадгалах ажил чинь Монголбанкны үндсэн ажил. Гэтэл бид жилээс жилд төгрөгийнхөө үнэ цэнийг алдаад байна, энэ дээр хийж, хэрэгжүүлэх ажил хэрэгтэй байна.

2 дугаарт бид олон улсын жишгийг нэвтрүүлж байна гэж хэлээд л, олон улсад хэрэглэгддэг юмнуудыг шууд А, Б-гүй хуулж тавьчихаад байдаг. Гэтэл нийтээрээ бид ибан гэх юм уу нэг баахан тоо цээжилдэг улс болчихлоо шүү дээ. Энийгээ хүртэл сайжруулаад, хамгийн сайныг нь нэвтрүүлж чадахгүй, ямар ч хэрэггүй олон улсын стандартыг Монголд авчирч хийгээд байх шаардлага байхгүй. Жишээлэхэд энэ бид

Орос руу Чойжилсүрэн сайд нэг хэдэн цахилгааны төлбөр төлж байгаа байх, нефтийн төлбөр төлж байгаа байх. Өөр нэг их сүртэй гадагш нь хийгээд байгаа нэг тийм хүн болгон гадагшаа хийгээд байгаа том гүйлгээ гэж байхгүй шүү дээ. Гэтэл яг тэрийг өдөр болгон хүн болгон, Монголын 3 сая 500 мянган хүн гадагшаа гүйлгээ хийдэг юм шиг л iban гэдэг тоо цээжлүүлэх ажлыг хийгээд байгаа байхгүй юу Монголбанк. Төгрөгийн ханшийг яаж тогтвортой байлгах юм, яавал энэ iban мэтийн хүнд хэрэггүй ажлуудаа хийх юм.

Тэгээд Монгол Ардын намынхан чинь бүүр хүлээн зөвшөөрчихсөн байна лээ шүү дээ. Даргын цүнх баригч нь бол дадлагажуулах хөтөлбөр юм гээд, буруу байхгүй юу даа. Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатарын туслах байсан нөхөр өөрийгөө дадлагажих хөтөлбөрт хамрагдчихсан гэж бодоод, Монголбанкин дээр очиж нэг их том дарга хийж байгаа, хийсэн ажил нь iban. Ийм хөлдүү, хөлдүү юм хийгээд байна гэж байгаа бол бид цаашдаа ийм 5, 10 жилийн төлөвлөгөөгөө баталж хийх ямар ч шаардлага байхгүй. Тэгээд энэ дээрээ тодорхой хариулт хүсэж байна.

Д.Үүрийнтуяа: Сангийн яам хариулах уу? Эдийн засгийн хөгжлийн яам, тэр Монголбанктай холбоотой төсвийн бодлоготой холбоотой асуудал дээр нь Сангийн яамнаас бэлдэж байгаарай. 4 номер, асуултад хариулж байгаа хүмүүс албан тушаал, нэрээ хэлээд яваарай. Протоколд үлдэх ёстой.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан Макро эдийн засгийн бодлогын газрын дарга. Гишүүний асуултад хариулъя. Инфляц, инфляцыг хэрхэн бууруулах, мөн ханштай холбоотой асуулт асуулаа гэж ойлголоо. Инфляц бол Монголбанкны үндсэн зорилтын нэг мөн, яалт ч үгүй мөн. Гэхдээ инфляцыг дотор нь хувааж харвал эрэлтийн гаралтай инфляц гэж байдаг. Энэ бол нийт бүтээгдэхүүнүүд массаараа нийтлэг үнэ нь өсөхийг эрэлтийн гаралтай инфляц гэж үзэж байгаа. Нийлүүлэлтийн гаралтай инфляц буюу тээвэр логистикийн хүндрэлээс бий болдог, тодорхой бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлтийн хомсдолоос бий болдог инфляц гэж байна. Тэгэхээр эрэлтийн гаралтай инфляцыг бол таны ярьж байгаа зөв, яалт ч үгүй Монголбанк хариуцна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц буюу хил боомт дээр саатал гаргахгүй байх бол Засгийн газрын ажил. Тодорхой бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлтийг тасалдуулахгүй яг чухал үед нь тэрнийг тасалдуулахгүй хангаж явах бол Засгийн газрын ажил байдаг. Энэ бол өнгөрсөн 5 жилд бий болсон ковидын үеэр гарсан олон кейсүүд дээр Засгийн газар энэ дээр манлайлан оролцож байсан. Тэгэхээр инфляцыг бол эрэлтийн гаралтай инфляцыг 5 хувьд барих, нийлүүлэлтийн гаралтай инфляцыг мөн 5 хувьд барих гээд Засгийн газар болон Монголбанкаар нь салгаж зорилтуудаа оруулсан байгаа. Тэгэхээр энэ дээр бол энд орсноороо ажиллаад явж таарна.

Ханшийг асуулаа. Ханш дээр бол тодорхой тоон зорилт бол тавиагүй. Тэр нь бол өөрөө зах зээлийн хүлээлтэд хүчтэй нөлөөлдөг учраас тийм оновчтой биш гэж үзсэн. Ханшийг тогтвортой байлгахад хийх ажил бол экспортоо л тогтвортой авч явах, тогтвортой нэмэгдүүлэх. Ингэснээр валютын нөөцийг хангалттай түвшинд хүргэх, ингэж байж валютын ханшийн зах зээл өөрөө тогтвортой байх ийм нөхцөл бүрдэнэ. Тэгэхээр экспортыг тоон зорилтоор нэмэгдүүлэх зорилтууд бол яг хариуцах эзэнтэйгээ орсон байгаа.

Боловсруулах үйлдвэр дээр асууж байна. Ард нь хөрөнгө оруулалтын жагсаалтууд байгаа. Хөрөнгө оруулалтуудын жагсаалтыг гаргахдаа ТЭЗҮ-тэй, ТЭЗҮ-гүй, урьдчилсан судалгаатай, судалгаагүй, эх үүсвэртэй, эх үүсвэргүй гээд

бүгдийг нь ангилж ялгаад оруулсан байгаа. Эх үүсвэргүй төслүүд олон байна гээд бас шүүмжлэлүүд нэлээд гарч байгаа. Эх үүсвэргүй төсөл гэдэг бол одоогоор эх үүсвэр нь тодорхой болоогүй. Гэхдээ хувийн хэвшил, төр, хувийн хэвшлийн түншлэл аль нь ч санхүүжүүлээд явахад зах зээлд нээлттэй, эдийн засгийн бүтцээ зөв болгох, 5 жилийн зорилтуудыг хангахад ач холбогдолтой дэмжих ёстой төслүүд гэдэг агуулгаар жагсаалтад заавал оруулсан байгаа. Ийм ингэж хариулъя.

Д.Үүрийнтуяа: Даваагийн Цогтбаатар гишүүн тодруулъя.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Тэр нөгөө бэлэн болчихсон байгаа төслүүдийнхээ жагсаалтыг өгөхгүй бол бидэнд бол одоо тараачихсан материал чинь 2, 3 хуудас цаас л байна. Энэ дахиад энэчээ биччихсэн байна энэ бизнес эрхлэгчид тулгарч байгаа хүнд суртлыг бууруулна гэж байгаа юм бас л Эдийн засгийн хөгжлийн яам гэхчхэн. Тэгээд энэ хуралдаан даргалагчид дахиад хэлэхэд чуулган дээр Эрүүл мэндийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга хоёр нь хоёулаа орж ирнэ гэсэн хоёулаа орж ирээгүй. Одоо энд Төрийн нарийн бичгийн дарга нь дуудагдаж байна, бас байхгүй. Жишээлэхэд энэ 6 сард шүдний эмнэлэг хийх гээд бүх шаардлагыг нь хангачихсан хүн материалаа өгөөд, одоо болтол авлига, хүнд суртлыг нь барахгүйгээр бизнес хийж чадахгүй сууж байна, зөвшөөрөл дээр нь гацчихсан. Гэх мэтчилэнгээр бид одоо байгаа асуудлаа шийдэж чадахгүй байж, цаашдаа нэг ийм баахан лоозонгоор цаас үйлдвэрлэх гээд байгаа байхгүй юу. Мэдээлэл чинь юу ч байхгүй. Тэгээд Эрүүл мэндийн яамнаас дахиад асуулт асуух гэхээр хариулах хүн байхгүй. Чуулган дээр яг ийм нөхцөл байдал байсан. Бат-Эрдэнэ даргад хэлсэн, яг нөхцөл байдал хэвээрээ, одоо Байнгын хороо руу халддаг боллоо.

Д.Үүрийнтуяа: Үндсэн чиглэл хэлэлцэж байгаа энэ цаг хугацаанд сайд, Төрийн нарийн бичиг, Төрийн нарийн бичиг ядаад оролцож байх ёстой шүү. Сайд нар ажил төрөл давхардаад, олон Байнгын хороодод хуваагдаж орж байгаа. Тийм учраас Төрийн нарийн бичиг бол зайлшгүй төлөөлж орох ёстой. Эрүүл мэндийн яам нэр өгчхөөд ирээгүй байна. Энэ Цогтбаатар гишүүний хэлж байгаа үнэн, энэ дээр анхаарах хэрэгтэй нэг.

2 дугаарт Цогтбаатар гишүүн энэ та бүхний өмнө, гишүүдийн өмнө тараасан байгаа энэ 4 хуудас материал дээр би бас тайлбар хэлье. Ер нь бол бидний гишүүдэд ирсэн материал энэ багцаараа байж байгаа шүү дээ. Энэ дотор ард нь хөрөнгө оруулалтын жагсаалт, бүх материалууд байж байгаа. Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд илүү нарийвчилж, гишүүдээ үзэхэд илүү хураангуй болгож, харьяалах асуудлынх нь хүрээнд энэ хураангуйлсан материал өнөөдөр 4 хуудас гэдэг чинь энэ материал нь байж байгаа шүү. Та бүхэн гишүүдэд тараагдсан материалаасаа дэлгэрүүлээд үзэх боломжтой байгаа. Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Б.Мөнхсоёл: Бид бүгдээрээ л яриад байгаа шүү дээ тал талд, нөгөө барилдахаасаа таахалзах нь гэгчээр гэдэг шиг, яах вэ сайд нар нь байхгүй байна. Тэгэхдээ энэ яам, тамгын газар, холбогдох газруудын энэ мэргэжилтнүүд олноороо ирэхээр бас санаа зовоод байдаг юм. Энэ ажлыг нь хийлгэхгүй байнга ингээд хурлаас хуралд авч яваад байдаг. Тэрэн дээр бас гишүүдийн алдаа байгаа байх гэж боддог хүний хувьд тэрийгээ хэлчихье.

2 дугаарт нь энэ байдал яагаад ийм болов гэдэг дээр бас хэлэлцэх эсэхийг шийдсэн, тэрэн дээр дэмжигдээд явсан та бүхэн мэдэж байгаа байх, тэгээд ажлын хэсэг үүсчихсэн, Их Хурлын гишүүдээс бүрдсэн ажлын хэсэг Тэмүүлэн гишүүн ахлаад ингээд үүсчихсэн байгаа. Тэгэхээр тэрэнд бас их гишүүд найдаад байгаа байх. Тэгээд магадгүй ингээд цалгардах маягтай болчхов уу даа гэж би хувь хүний хувьд ажиглаж байна.

3 дугаарт нь уг нь би өөрөө тухайн чуулган дээр хэлэлцэх эсэх дээр засаг өөрөө Засгийн газар өөрсдөө сайн ажиллавал зүгээр гэдэг үүднээс дэмжээгүй санал өгсөн юм. Тэгэхдээ нэгэнт ажлын хэсэг үүсчихсэн, тэгээд намынхаа зөвлөлөөс ингээд орчихсон ажиллахаар байна, өнөөдөр дахиж хуралдана. Тэгэхээр олон саналууд бас гишүүд гаргана. Бид бүүр хуваагаад харчихсан. Зүгээр нэг харамсалтай юм нь үг, үсгийн алдаа хүртэл засаад сууж байгаа нь гишүүдийн хийх ёстой ажил мөн ч юм уу, биш ч юм уу гэдэг юм байгаад байгаа юм.

Энэ төсөвтэй холбогдуулаад саналууд, тодорхой саналууд хэлэхэд энэ 7.4.3 дээр жишээлбэл аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулна гэж байна шүү дээ. Энэ угаасаа маш чухал. Аудитын тайланг хараад гишүүд асуулт асуудаг болж байна шүү дээ. Аудитын газар нь тайлан гаргаад, өчнөөн тоо баримтаар нотлоод, ингээд сайжруулах ёстой гэдгийг хэлчхээд байхад Засгийн газар дээр ч тэр, Их Хурал дээр ч тэр тодорхой шийдвэр гаргахгүй, сайжруулдаггүй нь манай Монгол Улсын маш их цаг хугацаа алдсан алдаа дутагдал мөн. Тэгэхээр энэ дээр ерөнхийдөө ерөнхий орчоод, 5 жилийн төлөвлөгөө болохоор ерөнхий ороод, жил тутам ингээд нарийвчилна гэсэн байдалтай байгаа байх. Тэгэхдээ л энэ мэтчилэн ингээд ерөнхий орчихоор чинь энэ баримт бичгийн ач холбогдлыг нь сулруулчихаад байгаа юм болов уу гэсэн санаа зоволт байна шүү. Энэ дээр цаашдаа анхаарах байх.

Тэгээд 3 гол саналуудаа хэлчихье. Төсвийн зарцуулалтад гарч буй зөрчлүүдийг арилгахын төлөө ийм нэг зорилго оруулмаар байна. Энэ дээр зөвхөн Үндэсний аудитын газар биш, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргадаг тайлан дээр гарсан, илрүүлсэн зөрчлүүдийг анхаардаг баймаар байна давхар. Нийслэлийн болон орон нутгийн төсвийн зарцуулалтад хяналт тавьдаг баймаар байна. 3 дугаарт нь нийслэлийн төсвийн зарцуулалтыг ил тод байлгадаг баймаар байна. Тэнд нэг хэсэг мөнгө хараа хяналтгүй, үр ашиггүй зарцуулагдах ийм боломж нэлээн газар авчихлаа шүү. Энэ төрлийн зорилгууд бол ороогүй байна лээ. Энэ 5 жилийн учраас бусад зорилгууд аягүй ийм ерөнхий байгааг бол хэлчихлээ түрүүн би. Үг.../минут дуусав/

Д.Үүрийнтуяа: Үндэсний аудитын газар Цэдэнжав дарга хариулъя. 8 дугаар микрофон.

3.Цэдэнжав: Үндэсний аудитын газар Ерөнхий аудиторовн орлогч Цэдэнжав. Төрийн аудитын байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг дээшлүүлэхтэй холбоотой саналд талархалтай хандаж байна. Төрийн аудитын байгууллага шинэ бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр аудитын шийдвэрийн хэрэгжилтийг биелүүлэх, энэний үр нөлөөг дээшлүүлэх чиглэлд шинээр зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй болсон байгаа. Энэ арга хэмжээний хүрээнд бид аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхэд харилцагч талуудыг, ялангуяа Улсын Их Хурал, шийдвэр гаргах түвшинд Улсын Их Хурлын дэмжлэгийг авч ажиллах талаар тодорхой бодлого боловсруулаад ажиллаж байгаа. Удахгүй бид Төсвийн байнгын хороон дээр

аудитын шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой хууль, эрх зүйн хувьд Их Хурлаасаа ямар дэмжлэг авах вэ гэдэг асуудлаар танилцуулга хийнэ.

Энэ Монгол Улсыг 26-аас 30 он, 2026-аас 2030 онд хөгжүүлэх төлөвлөгөөнд манай аудитын шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах нэг арга хэмжээ бол орсон. Энийг 5 жилд нь бид төлөвлөөд ажиллаж байгаа. Олон улсын туршлагын дагуу аудитын шийдвэр болон төрийн аудитын байгууллагын санхүүгийн үр өгөөжийг тооцох асуудлыг бид шинэчлэн боловсруулаад та бүхэнд танилцуулна.

Д.Үүрийнтуяа: Гишүүд асуулт асууж дууслаа тогтоолын төсөлтэй холбогдуулан. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14-д заасны дагуу зарчмын зөрүүтэй санал бол ирүүлээгүй байна. Ингээд Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Түвшин гишүүн Эдийн засгийн байнгын хороонд танилцуулна. Батболд гишүүн, Батболд гишүүн танилцуулъя Эдийн засгийн байнгын хороонд.

12.32 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА